

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн
профессор, хууль зүйн ухааны доктор (Ph.D),
цагдаагийн хурандаа Б. Одбаатар*

НИЙГМИЙН ШИНЖТЭЙ ГАМШИГТ БАЙДАЛ ҮҮСЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

Цаг агаарын эрс тэс өөрчлөлт, байгаль орчны тэнцвэрт байдлын алдагдлын улмаас байгалийн гамшиг, аюулт ноцтой үзэгдлийн давтамж сүүлийн жилүүдэд байнга нэмэгдэж түүний улмаас учирч буй хор хохирол, аюул занал, хөнөөлийн цар хүрээ, хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа нь ард, иргэдийн хэвийн амьдрах нөхцөлд нөлөөлөөд зогсохгүй улмаар улс, нийгмийг бүхэлд нь хамарсан гамшигт аюул, хор уршгийг бий болгож онц байдлын хэмжээнд хүрэх явдал чгарч байна¹.

Мөн түүнчлэн улс орны нийгэм, эдийн засгийн тогтворгүй байдал, улс төрийн нам, эвсэл, бүлгийн үзэл бодлын зөрчлөөс үүдэлтэй нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болж энэ нь даамжирч онц байдлын хэмжээнд хүрч байсан, зэвсэглэн онц ноцтой гэмт хэрэг бүлэглэн үйлдэж хүн барьцаалж, улмаар олон аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан эрлийн болон дайчлан баривчлах ажиллагааг зохион байгуулахад хүрч, олон нийтийг цочроон, түгшүүрт байдал бий болгож байсан ноцтой гэмт хэргийн баримтууд ч олон байна.

Бүр цаашлаад нийгмийн шинжтэй гамшгийн аюул зарим тохиолдолд тухайн улс орныхоо дотоод нөхцөл байдлын хяналтаас гарч бүс нутаг, үндэстэн, хил дамнан дэлхийн улс, гүрнүүдийн аюулгүй байдлын хэмжээнд очсон байгааг өнөөдөр дэлхий нийтийн анхаарлын төвд байгаа Сири, Украин зэрэг улсуудын нөхцөл байдал тодорхой харуулж улмаар даяаршлын эринд аюулгүй байдлын асуудал зөвхөн нэг улсынх бус хэдийнээ дэлхий нийтийн чанартай болсон байна.

Гамшиг осол, онц байдлын үед цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах² хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хувьд зайлшгүй татагдан оролцож бусад хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллах, зарим тохиолдолд удирдан зохион байгуулах, үүссэн нөхцөл байдлыг аль болох хор хохирол багатайгаар түргэн шуурхай хэвийн нөхцөл байдалд оруулах олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай болдог.

¹ Гамшиг ослын улмаас дэлхийд жилд дунджаар 3 сая хүн амь насаа алдаж, учирч буй хохирол 50-100 тэрбум ам.долларт хүрч байна. Мөн байгалийн болон техникийн гаралтай гамшигийн улмаас хохирогчдын тоо 8,6%, материаллаг хохирлын хэмжээ 10,4%-иар тус тус өсөж байна. Манай улсад жилд дунджаар 3000 гаруй гамшиг, осол гарч үүний улмаас 200 гаруй хүн амь насаа алдаж, 10 мянга гаруй толгой мал хорогдож, улсад 200 гаруй тэрбум төгрөгний хохирол гардаг байна. Цахим эх сурвалж, холбоос:<http://gantumur.0111.blog.gogo.mn/reac/entry211201>, <http://mongol.tv.mn>

² Цагдаагийн албаны тухай Монгол Улсын хууль. [2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр УИХ-аас баталсан]: Цахим эх сурвалж, холбоос: <http://vvwww.legalinfo.mn/law/details/9288>

Өөрөөр хэлбэл цагдаагийн байгууллага нь байгалийн болон техникийн шинжтэй гамшиг ослын хор уршгийг арилгах үед (*үер ус, газар хөдлөлт, зуд, салхи, шуурга, гал түймэр, аянга цахилгаан, гоц халдварт өвчин, тарваган тахал г.м.*) онцгой байдлын алба болон бусад хууль сахиулах албадтай хамтран ажиллах, нийгмийн шинжтэй (*нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн болон зэвсэглэсэн этгээдийг эрэн сурвалжлах, дайчлан баривчлах, гэмт бүлэглэлийн үйл ажиллагааг таслан зогсоох, дайчлан баривчлах, барьцаалагдсан этгээдийг чөлөөлөх, улсын онц чухал объектод халдахаас урьдчилан сэргийлэх, халдсан үйлдлийг таслан зогсоох г.м.*) гамшигийн үед түүнийг таслан зогсоох ажиллагааг бие даан удирдан зохион байгуулж хэрэгжүүлэх үүрэгтэй.

Үүний тулд цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтан бүрт гамшиг ослын үед нөхцөл байдлыг бодитоор үнэлж хүч, хэрэгсэлийг оновчтой, зөв хуваарилах, зохих шийдвэрийг богино хугацаанд гаргаж хэрэгжүүлэх удирдан зохион байгуулах мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байх бодит хэрэгцээ, шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Гамшиг судлалын хамрах хүрээнд өнөөдөр бий болоод байгаа гамшиг ослыг ерөнхийд нь үүсэн гарч байгаа хэлбэрээр нь байгалийн, техникийн, нийгмийн шинжтэй гэсэн үндсэн 3 хэсэгт хуваан авч үзэж байна. Байгалийн болон техникийн шинжтэй гамшиг ослын хор уршиг, түүнийг арилгах талаар одоо бараг хүн бүр мэдэж энэ гамшигт байдлын талаар тодорхой мэдлэгийг олж авсан байдаг.

Үүнээс гадна дайн байлдаан, алан хядах ажиллагаа, хүн хулгайлах гэмт хэрэг, мөрийтэй тоглоом, нийгэм-эдийн засгийн хямрал, өсгөлөн, ядуурал, хүн амын хэт төвлөрөл, нягтрал, агаарын бохирдол гэх мэт нийгмийн шинж чанар бүхий гамшигийн тоо, давтамж байнга өсөн нэмэгдэж, дэлхийн хэмжээнд томоохон байр суурийг хэдийнээ эзлэж үүнээс урьдчилан сэргийлэх, гарах арга замыг бүх нийтээр хайхад хүргээд байна.

Статистик тоо баримтаас харахад нийгмийн хөгжлийн 5500 жилийн хугацаанд нийтдээ 14513 удаа дайн болж үүнд 3 млрд хүн амь насаа алджээ. Энэ хугацаанд хүн төрөлхтөнд ердөө 292 жил нь “энхийн” буюу амгалан жил байжээ.

Материаллаг хохирлын хувьд 500 квинтриллон швейцар франк байгаа нь дэлхийг экватороор 10 м зузаан, 8 м өргөн алтан туузаар ороож хүрэх хэмжээ юм.

Тэгвэл **“Нийгмийн шинжтэй гамшиг гэж юу?”** гэсэн асуулт зүй ёсоор урган гарна.

Нийгмийн шинжтэй гамшиг гэдэг нь нийгэмд аюултай үйл явдлын уршгаар тодорхой нутаг дэвсгэрт олон хүний амь нас, эрүүл мэнд болон хүрээлэн байгаа байгаль орчинд тодорхой хэмжээний материаллаг ба материал бус хохирол учирсан, хүмүүсийн амьдралын хэвийн үйл ажиллагааны нөхцөл алдагдсан эсвэл дээрхи хор уршиг үүсч болох хэмжээнд хүртлээ нөхцөл байдал хүндэрсэн байхыг ойлгодог байна¹.

Тэгвэл улс орны доторхи нам, эвсэл бүлгийн үл ойлголцох байдал, үзэл бодлын зөрчил, буруу алдаатай шийдвэр, аливаа хямралт байдлыг нийгмийн шинжтэй гамшигт байдалд хүрэхээс урьдчилан сэргийлэх, эсвэл нэгэнт бий болсон

¹ http://www.0zd.ru/sociologiya/obshhestvoznanie/chrezvychaynye_situacii_socialnogo.html

нөхцөл байдлын хүрээ хэмжээг даамжруулахгүй байхад чиглэсэн арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлж, зөв оновчтой шийдвэрийг богино хугацаанд гаргаж хэрэгжүүлэх шаардлагатай байдаг. Энэ нь нэг талаас үүссэн нөхцөл байдлыг бодитоор үнэлж шуурхай арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлж үүсч болох нөхцөл байдлаас урьдчилан сэргийлж байгаа хэрэг боловч нөгөө талаас цааш өргөн утгаараа улс орны үндэсний аюулгүй байдал, эв нэгдлийг хангахад чиглэсэн улс орны хувь заяатай холбоотой асуудал юм.

Нийгмийн шинж бүхий гамшигт байдал үүссэн үед нийгэм, улс орныг хамарсан олон сөрөг үзэгдлүүд бий болж болох ба үүний хамгийн ноцтой хэлбэрүүдийн талаар авч үзэж түүнтэй хэрхэн яаж тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар авч үзье.

1. Нийгмийн шинжтэй гамшигт байдал үүссэн үед үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлийн тоо, түүний улмаас учирсан хохирлын хэмжээ амьдралын хэвийн нөхцөлд үйлдэгдсэн хэрэг, зөрчлөөс ямагт их байдаг. Энэ нь хүмүүсийн санаа сэтгэл өөрчлөгдсөн, тэдний амьдрах баталгаа, нөхцөл алдагдсан, ашиг орлого багассан, төр засагт итгэх итгэл буурсан, түүнчлэн гамшигт байдлыг далимдуулж амар хялбар аргаар хөрөнгөжих бусармаг санаа бодлоо хэрэгжүүлэх гэх мэт гадаад, дотоод олон хүчин зүйлийн нөлөөлөлөөс болж энэ нь зарим нэгэнд нь ёстой л нөгөө “Дайны хажуугаар дажин” гэдэг нь л болдог байна. Тэртээ 1966 онд Улаанбаатар хотод болсон их үерийн үед урсаж явсан эд зүйл, хивсний хойноос яваад үерт урсан амь насаа алдаж байсан өрөвдмөөр, гашуун түүх ч байдаг.

Улс орны удирдлага, төр засгийн анхаарал гамшигт байдлын үед түүнээс аль болох богино хугацаанд гарах, амьдралын хэвийн нөхцөлд улс орныг түргэн шилжүүлэхэд чиглэж хууль сахиулах чиг үүрэг бүхий бүх албадын анхаарал нэгэн зүгт чиглэсэн энэ үеийг далимдуулан зарим нэг гэмт бүлэг, бүлэглэлийн үйл ажиллагаа идэвхжих явдал байдаг. Энэ нь одоо дэлхий нийтийн анхаарлын төвд байгаа Сири, Украин зэрэг орны жишээ дээрээс харж болох юм. Энэ хугацаанд энгийн хүний амь нас хохирсон, банк, дэлгүүрүүд дээрэм тонуулж өртөж их хэмжээний хохирол учирсан ноцтой гэмт хэргийн жишээ баримт олон байна.

Манай улсын тухайд ч гэсэн энэ байдал мөн тойроод өнгөрөөгүй. 2008 оны 7 сарын 1-нд болсон сонгуулийн үр дүнгийн маргаанаас үүдэлтэй жагсаал цуглаан онц байдлын хэмжээнд хүрч улмаар хууль хяналтын байгууллагын хяналтаас гарч улмаар 5 хүний амь нас хохирсон, барилга байшин шатсан, эд зүйл эвдсэн сүйтгэсэн, дэлгүүр дээрэмдсэн гэх мэт ноцтой хэргийн бодит жишээ баримт байсаар байна.

2. Нийгмийн шинжтэй гамшгийн үед бий болох ноцтой нөхцөл байдлуудын нэг хэлбэр нь гэмт хэрэг, зөрчлөөс гадна нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэх явдал юм.

Ер нь дэлхий нийтэд өрнөөд байгаа нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын явцад дүн шинжилгээ хийж авч үзэхэд эдгээр нь гол төлөв нийгэм эдийн засгийн хямрал, төрийн үйл ажиллагааны зохицуулалтын системийн хяналт, үйл ажиллагааны алдаа, сул дорой байдал, нийгмийн салбар дахь бодлогын алдаа, нийт хүн амын амьдралын хэвийн нөхцлийн түвшин буурах, үзэл суртал, бодлогын хэрэгжилтийн алдаа завхрал, нам, эвсэл бүлэг хоорондын зөрчил, нийгмийн шинэчлэлт өөрчлөлт гэх мэт олон хүчин зүйлийн эх үүсвэрээс гаралтай байх бөгөөд

энэ нөхцөл байдлыг тухай бүрийн оновчтой шийдвэрээр зохицуулж чадаагүйн улмаас улам бүр хүрээгээ тэлж цаашдаа олон нийтийг хамарсан эмх замбааргүй байдалд хүрдэг болох нь ажиглагдаж байна. Зөвхөн эмх замбараагүй байдал тухайн үед үүсээд ч зогсох бус харин ч улс орны дотоод зөрчил түүнийг хамрах хүрээ хэмжээнээс хальж дэлхий нийтийн анхаарлын төвд орж бүс нутгийн аюулгүй байдлын хэмжээнд хүрч олон сар жилээр үргэлжилсэн гамшигт байдлыг бий болгож байгаа улс орны жишээ баримт өнөөдөр бодитоор бий болоод байна.

Үүнийг дагаад онц хүнд гэмт хэргүүд олноор үйлдэгдэж улс орны гэмт хэргийн нөхцөл байдал хууль хяналтын багууллагын бүрэн хяналтаас ч гарах аюултай юм. Ийм нөхцөлд гол төлөв террорист халдлага, хүн амь, дээрэм, хулгай, хүч хэрэглэсэн онц ноцтой гэмт хэргүүд олноор үйлдэгдээд зогсохгүй нийтийн дунд түгшүүрт байдал бий болох сөрөг үр дагавартай байдаг. Энэ бүхнийг тоочоод байвал олон нийтийн сэтгэлийг түгшээсэн, иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулсан цаашлаад нийгмийн сэтгэлд зүйд хортойгоор нөлөөлөх хэмжээний гамшигт хор уршгууд бий болсон гээд олон жишээ баримтууд гарч ирнэ.

Тэгвэл энэ бүхнээс яаж урьдчилан сэргийлэх вэ? Ийм нөхцөл байдал үүссэн үед яах вэ? ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх вэ? гэсэн асуултууд хөврөн гарна.

Иймд дараах арга хэмжээг нэн яаралтай авч хэрэгжүүлэх нь чухал гэж үзэж байна. Үүнд:

1. Дээр дурьдсан аливаа хэлбэрийн зөрчил маргааны үед нийгмийн шинжтэй гамшигт байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх гол үйл ажиллагааны нэг хэлбэр нь олон нийтийн санаа бодлыг зөв удирдан чиглүүлэх явдал юм.

2. Гамшгийн үед үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох ажиллагаанд онцгой анхаарч гэмт бүлэглэл, гэмт этгээдүүдийн гэмт санаа бодлоо хэрэгжүүлэх боломж нөхцлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авч, нутаг дэвсгэрийн хяналтыг сайжруулах нь чухал.

3. Нийгмийн шинжтэй гамшигт байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх аливаа улс төрийн хүчнүүдээс дээрхи нөхцөл байдал үүссэн буюу, үүссэх нөхцөл байдал бий болсон даруйд үндэсний эв нэгдлийг сахин хамгаалах, ийм нөхцөлд хамтран ажиллах эрх зүйн баримт бичгийг боловсруулан гаргах.

4. Нийгмийн шинжтэй гамшигт байдал үүссэн үед хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтран ажиллах хууль эрх зүйн орчинг яаралтай бүрдүүлэх зэрэг нь өнөөдөр нэн яаралтай авч хэрэгжүүлэх арга хэмжээнд зүй ёсоор тооцогдох болоод байна.

*ХСИС-ийн Ерөнхий эрдмийн сургуулийн
Албаны бэлтгэлийн тэнхимийн эрхлэгч,
цагдаагийн дэд хурандаа, докторант Б.Батжав*

“ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ТУСГАЙ БЭЛТГЭЛ” СУРГАЛТЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, МӨН ЧАНАР

Аливаа улс орон өөрийн гэсэн хууль сахиулах мэргэжлийн чадварлаг цагдаагийн албатай байх нь түүнд алба хааж буй алба хаагчдын мэргэжлийн боловсрол, ур чадвар хандлагаас ихээхэн хамааралтай байдаг. Тиймээс орчин цагт